**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2026/516/НА-СТА-ТШЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр<br>Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: С.Гантөгс<br>Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Н.Бадамхатан<br>Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 139

танай ______ -ны № ______ -т

НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА, АХЛАХ ПРОКУРОР С.ХИШИГЖАРГАЛ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Прокурорын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

НИТХ-ын даргын А/35, А/152, А/261 дүгээр захирамжуудаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд нэмэлт санхүүжилтийн дансаар 58.6 сая төгрөгийн санхүүжилт авч, Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Авлигатай тэмцэх газартай хамтран сургалт, сэдэвт хэлэлцүүлэг, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

1426050065

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\Word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt - .docx

**Аудитын гол асуудал**

Нийслэлийн Прокурорын газрын тайлант оны төсөв өмнөх оны төсвийн гүйцэтгэлээс 33.04 хувиар нэмэгдсэн нь УИХ-ын 2025 оны 24 дүгээр тогтоолоор прокуроруудын, ЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоож, нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Нийт төсвийн 96.1 хувийг цалин хөлстэй холбоотой зардал эзэлж байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Бусад асуудал**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилт дэвшүүлэн, 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narengua.l\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt -.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | | **3,782,630,442.59** | **2,526,716,284.02** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **4** | 3,605,976,332.43 | 2,350,463,893.19 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | | 3,605,976,332.43 | 2,350,463,893.19 |
| **3121** | **Төгрөг** | | 3,588,709,268.88 | 2,332,509,268.88 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | | 3,588,709,268.88 | 2,332,509,268.88 |
| **3122** | **Гадаад валют** | | 17,267,063.55 | 17,954,624.31 |
| 31221 | Төрийн сангийн харилцах | | 17,267,063.55 | 17,954,624.31 |
| **33** | **АВЛАГА** | **5** | 172,116.83 | 1,434,290.19 |
| **335** | **Бусад авлага** | | 172,116.83 | 1,434,290.19 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | 172,116.83 | 1,034,629.64 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | | - | 399,660.55 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | | 31,184,000.00 | - |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | | 31,184,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **6** | 145,297,993.33 | 174,818,100.64 |
| **354** | **Хангамжийн материал** | | 145,297,993.33 | 174,818,100.64 |
| 35410 | Бичиг хэргийн материал | | 7,317,300.00 | 8,651,210.00 |
| 35420 | Аж ахуйн материал | | 2,386,659.00 | 2,541,060.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | 1,440,000.00 | 3,090,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 5,090,000.00 | 880,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 129,064,034.33 | 159,655,830.64 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | | **2,571,503,141.62** | **2,603,350,585.10** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **7** | 2,571,503,141.62 | 2,603,350,585.10 |
| **392** | **Биет хөрөнгө** | | 1,674,286,931.62 | 1,706,464,375.10 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | | 1,056,449,899.00 | 1,068,149,899.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (283,242,513.66) | (365,564,702.14) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | | 244,635,694.41 | 613,775,694.41 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | | (82,057,935.69) | (243,049,278.21) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | | 662,704,797.22 | 692,213,416.62 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | | (250,680,504.98) | (324,123,312.81) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 412,495,921.24 | 380,906,855.30 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | | (86,018,425.92) | (115,844,197.07) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | | 897,216,210.00 | 896,886,210.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 897,876,210.00 | 897,876,210.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | | (660,000.00) | (990,000.00) |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | | **6,354,133,584.21** | **5,130,066,869.12** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **3,606,082,264.77** | **2,350,463,893.19** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **9** | 3,606,082,264.77 | 2,350,463,893.19 |
| **413** | **Өглөг** | | 105,932.34 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | | 105,932.34 | - |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | | 3,605,976,332.43 | 2,350,463,893.19 |
| 41430 | Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого | | 3,605,976,332.43 | 2,350,463,893.19 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **10** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | | **2,748,051,319.44** | **2,779,602,975.93** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | | 2,748,051,319.44 | 2,779,602,975.93 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | | 1,477,332,566.50 | 1,477,332,566.50 |
| 51101 | Өмч: - төрийн | | 1,477,332,566.50 | 1,477,332,566.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | | 1,243,807,124.22 | 1,275,358,780.71 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 1,243,807,124.22 | 1,243,807,124.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | - | 31,551,656.49 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | | 26,911,628.72 | 26,911,628.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | | **6,354,133,584.21** | **5,130,066,869.12** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Тодруулга | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2** | **8,035,254,157.37** | **10,032,176,580.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **455,575,857.37** | **390,009,963.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | | 455,575,857.37 | 390,009,963.32 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 455,575,857.37 | 390,009,963.32 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -үндсэн хөрөнгө | | 304,814,523.41 | 388,834,963.32 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого -бараа материал | | 60,289,294.00 | 1,175,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | | 90,472,039.96 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **7,579,678,300.00** | **9,642,166,617.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | | 7,476,618,300.00 | 9,583,616,617.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 7,476,618,300.00 | 9,583,616,617.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 103,060,000.00 | 58,550,000.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 103,060,000.00 | 58,550,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3** | **7,682,849,463.04** | **9,958,241,218.84** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **7,682,849,463.04** | **9,958,241,218.84** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 7,302,784,025.98 | 9,761,882,864.94 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 6,001,386,274.58 | 8,119,275,532.85 |
| 210101 | Үндсэн цалин | | 3,264,474,074.17 | 4,799,670,987.28 |
| 210102 | Нэмэгдэл | | 1,835,828,696.07 | 2,578,232,067.07 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 333,225,902.25 | 376,572,000.00 |
| 210104 | Урамшуулал | | 567,857,602.09 | 364,800,478.50 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | | 755,691,824.47 | 1,016,737,417.92 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 515,565,951.95 | 693,572,744.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 60,565,477.59 | 81,673,445.89 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 30,038,538.84 | 40,702,668.94 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 29,897,871.16 | 40,157,713.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 119,623,984.93 | 160,630,845.41 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 46,045,822.69 | 44,988,903.31 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 29,035,798.45 | 30,585,904.76 |
| 210302 | Түлш, халаалт | | 12,040,416.93 | 8,136,106.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | 4,969,607.31 | 6,266,892.03 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 100,575,701.94 | 98,167,214.01 |
| 210401 | Бичиг хэрэг | | 38,513,710.00 | 40,989,890.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 20,350,500.00 | 22,065,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 8,549,582.19 | 11,953,601.32 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 1,839,125.00 | 1,826,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 23,835,260.00 | 17,827,369.00 |
| 210408 | Бараа материал актлалсны зардал | | 7,487,524.75 | 3,504,603.69 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 22,644,890.00 | 21,859,290.00 |
| 210604 | Урсгал засвар | | 22,644,890.00 | 21,859,290.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | 5,368,600.00 | 2,942,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 5,368,600.00 | 2,942,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 35,816,369.52 | 26,844,192.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 34,018,199.52 | 24,148,300.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 310,080.00 | 1,207,802.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 1,488,090.00 | 1,488,090.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 335,254,542.78 | 431,067,814.85 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 91,343,200.00 | 104,764,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 2,600,000.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | | 241,311,342.78 | 326,303,814.85 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 380,065,437.06 | 196,358,353.90 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | 26,075,629.00 | 111,205,196.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 17,315,629.00 | 111,205,196.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 8,760,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | 353,989,808.06 | 85,153,157.90 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 353,989,808.06 | 85,153,157.90 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | | **352,404,694.33** | **73,935,361.48** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | | - | 42,383,704.99 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-үндсэн хөрөнгө | | - | 42,383,704.99 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | | - | (42,383,704.99) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | | **352,404,694.33** | **31,551,656.49** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **10,684,810,727.52** | **11,557,374,870.33** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **3,105,132,427.52** | **1,915,208,253.33** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 3,105,132,427.52 | 1,915,208,253.33 |
| 120009 | Бусад орлого | 3,105,132,427.52 | 1,915,208,253.33 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **7,579,678,300.00** | **9,642,166,617.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 7,476,618,300.00 | 9,583,616,617.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 7,476,618,300.00 | 9,583,616,617.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 103,060,000.00 | 58,550,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 103,060,000.00 | 58,550,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **7,714,613,587.52** | **12,813,574,870.33** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,714,613,587.52** | **12,813,574,870.33** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **7,134,548,150.46** | **9,447,216,516.43** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 6,005,321,562.10 | 8,120,864,663.04 |
| 210101 | Үндсэн цалин | 3,268,409,361.69 | 4,538,264,840.41 |
| 210102 | Нэмэгдэл | 1,835,828,696.07 | 2,877,629,948.32 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 333,225,902.25 | 375,409,587.51 |
| 210104 | Урамшуулал | 567,857,602.09 | 329,560,286.80 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 755,758,008.96 | 1,017,324,646.76 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 515,632,136.44 | 653,769,431.29 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 60,565,477.59 | 91,511,192.16 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 30,038,538.84 | 45,159,910.11 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 29,897,871.16 | 44,975,506.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 119,623,984.93 | 181,908,606.81 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 46,045,822.69 | 44,988,903.31 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 29,035,798.45 | 30,585,904.76 |
| 210302 | Түлш, халаалт | 12,040,416.93 | 8,136,106.52 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,969,607.31 | 6,266,892.03 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 94,199,687.19 | 85,677,421.32 |
| 210401 | Бичиг хэрэг | 42,143,020.00 | 40,146,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,768,700.00 | 16,780,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8,549,582.19 | 11,953,601.32 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,839,125.00 | 1,826,750.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,899,260.00 | 14,970,270.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | 4,158,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | 4,158,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 26,197,950.00 | 34,029,590.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,197,950.00 | 34,029,590.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,014,600.00 | 3,542,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,014,600.00 | 3,542,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 66,143,669.52 | 48,233,792.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 64,345,499.52 | 45,537,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 310,080.00 | 1,207,802.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,488,090.00 | 1,488,090.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 135,866,850.00 | 88,397,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 134,066,850.00 | 88,397,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,800,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **580,065,437.06** | **3,366,358,353.90** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 200,000,000.00 | 3,170,000,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 200,000,000.00 | 3,170,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,075,629.00 | 111,205,196.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 17,315,629.00 | 111,205,196.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,760,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 353,989,808.06 | 85,153,157.90 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,970,197,140.00** | **(1,256,200,000.00)** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **69,000,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **69,000,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 69,000,000.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 69,000,000.00 | - |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(69,000,000.00)** | - |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 14 | **Бусад эх үүсвэр** | 198,948.38 | 879,290.26 |
| 25 | **Санхүүгийн үйл ажиллагааны зардал** | 165,603.80 | 191,729.50 |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүү | 165,603.80 | 191,729.50 |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **33,344.58** | **687,560.76** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 2,901,230,484.58 | (1,255,512,439.24) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 704,745,847.85 | 3,605,976,332.43 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 3,605,976,332.43 | 2,350,463,893.19 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,477,332,566.50 | 26,911,628.72 | 891,402,429.89 | 2,395,646,625.11 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,477,332,566.50** | **26,911,628.72** | **891,402,429.89** | 2,395,646,625.11 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 352,404,694.33 | 352,404,694.33 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,477,332,566.50** | **26,911,628.72** | **1,243,807,124.22** | 2,748,051,319.44 |
| **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,477,332,566.50** | **26,911,628.72** | **1,243,807,124.22** | 2,748,051,319.44 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,477,332,566.50** | **26,911,628.72** | **1,243,807,124.22** | 2,748,051,319.44 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 31,551,656.49 | 31,551,656.49 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,477,332,566.50** | **26,911,628.72** | **1,275,358,780.71** | 2,779,602,975.93 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 9,592,802,700.00 | 9,498,463,459.10 | (94,339,240.90) | 99.0% |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 9,592,802,700.00 | 9,498,463,459.10 | (94,339,240.90) | 99.0% |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 9,472,411,400.00 | 9,387,258,263.10 | (85,153,136.90) | 99.1% |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 8,175,956,300.00 | 8,120,056,409.71 | (55,899,890.29) | 99.3% |
| Үндсэн цалин | 3,812,374,200.00 | 4,537,456,587.08 | 725,082,387.08 | 119.0% |
| Нэмэгдэл | 3,533,643,100.00 | 2,877,629,948.32 | (656,013,151.68) | 81.4% |
| Унаа хоолны хөнгөлөлт | 442,461,100.00 | 375,409,587.51 | (67,051,512.49) | 84.8% |
| Урамшуулал | 387,477,900.00 | 329,560,286.80 | (57,917,613.20) | 85.1% |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,040,964,800.00 | 1,017,324,646.76 | (23,640,153.24) | 97.7% |
| Тэтгэврийн даатгал | 695,628,100.00 | 653,769,431.29 | (41,858,668.71) | 94.0% |
| Тэтгэмжийн даатгал | 86,358,700.00 | 91,511,192.16 | 5,152,492.16 | 106.0% |
| ҮОМШӨ-ний даатгал | 43,171,300.00 | 45,159,910.11 | 1,988,610.11 | 104.6% |
| Ажилгүйдлийн даатгал | 43,161,400.00 | 44,975,506.39 | 1,814,106.39 | 104.2% |
| Эрүүл мэндийн даатгал | 172,645,300.00 | 181,908,606.81 | 9,263,306.81 | 105.4% |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 45,020,100.00 | 44,988,903.31 | (31,196.69) | 99.9% |
| Гэрэл, цахилгаан | 25,427,200.00 | 30,585,904.76 | 5,158,704.76 | 120.3% |
| Түлш, халаалт | 14,631,100.00 | 8,136,106.52 | (6,494,993.48) | 55.6% |
| Цэвэр, бохир ус | 4,961,800.00 | 6,266,892.03 | 1,305,092.03 | 126.3% |
| **Хангамж, бараа материалын зардал** | 85,776,500.00 | 82,717,421.32 | (3,059,078.68) | 96.4% |
| Бичиг хэрэг | 38,935,300.00 | 38,986,800.00 | 51,500.00 | 100.1% |
| Тээвэр, шатахуун | 14,368,000.00 | 14,980,000.00 | 612,000.00 | 104.3% |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 16,698,800.00 | 11,953,601.32 | (4,745,198.68) | 71.6% |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,796,400.00 | 1,826,750.00 | 30,350.00 | 101.7% |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,978,000.00 | 14,970,270.00 | 992,270.00 | 107.1% |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 34,037,800.00 | 34,029,590.00 | (8,210.00) | 100.0% |
| Урсгал засвар | 34,037,800.00 | 34,029,590.00 | (8,210.00) | 100.0% |
| **Томилолт, зочны зардал** | 2,972,500.00 | 2,942,500.00 | (30,000.00) | 99.0% |
| Дотоод албан томилолт | 2,972,500.00 | 2,942,500.00 | (30,000.00) | 99.0% |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 21,263,400.00 | 18,983,792.00 | (2,279,608.00) | 89.3% |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,472,300.00 | 16,287,900.00 | (184,400.00) | 98.9% |
| Тээврийн хэрэгслийн татвар | 3,303,000.00 | 1,207,802.00 | (2,095,198.00) | 36.6% |
| Газрын төлбөр | 1,488,100.00 | 1,488,090.00 | (10.00) | 100.0% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 62,262,000.00 | 62,057,000.00 | (205,000.00) | 99.7% |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 62,262,000.00 | 62,057,000.00 | (205,000.00) | 99.7% |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 120,391,300.00 | 111,205,196.00 | (9,186,104.00) | 92.4% |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 120,391,300.00 | 111,205,196.00 | (9,186,104.00) | 92.4% |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 111,205,300.00 | 111,205,196.00 | (104.00) | 100.0% |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,186,000.00 | - | (9,186,000.00) | 0.0% |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 9,592,802,617.00 | 9,498,655,188.60 | (94,147,428.40) | 99.0% |
| **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 9,592,802,617.00 | 9,498,463,459.10 | (94,339,157.90) | 99.0% |
| Улсын төсвөөс санхүүжих | 9,592,802,617.00 | 9,498,463,459.10 | (94,339,157.90) | 99.0% |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 3,605,976,332.43 | 3,605,976,332.43 | |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 2,350,463,893.19 | 2,350,463,893.19 | |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 112 | 99 | (13) | 88.4% |
| Гүйцэтгэх ажилтан | 94 | 81 | (13) | 86.2% |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 112 | 99 | (13) | 88.4% |
| Төрийн тусгай албан хаагч (ТТ) | 77 | 67 | (10) | 87.0% |
| Ажлын албаны албан хаагч (АА) | 18 | 16 | (2) | 88.9% |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 17 | 16 | (1) | 94.1% |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.* /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **58,550,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **58,550,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 58,550,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,960,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,160,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,800,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 29,250,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,250,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,340,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,340,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 58,550,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 58,550,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 58,550,000.00 |

# 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн тодруулга тайланд дахин үнэлгээний нэмэгдэл, хорогдол гэж тайлагнасан. | 1 | 15,608.4 | | | 1 | 15,608.4 | 1 | 15,608.4 | | | | |
| Албан хаагчдын орон сууцны капиталжуулах зардлыг бүртгээгүй. | 1 | 11,700.0 | | | 1 | 11,700.0 | 1 | 11,700.0 | | | | |
| Мөнгөн хөрөнгийн харилцахын баримтын бүрдүүлэлтийг дутуу гүйлгээ хийсэн. | 1 | 19,800.0 | 1 | 19,800.0 | | | 1 | 19,800.0 | | | | |
| **Дүн** | **3** | **47,108.4** | **2** | **19,800.0** | **2** | **27,308.4** | **3** | **47,108.4** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Цалингаас тооцсон НДШ болон ХХОАТ-ыг зөрүүтэй тусгасан. | 1 | 1,434.3 | | | | | 1 | 1,434.3 | | | | |
| Барилгын хувийн хэргийг бүрэн хөтлөөгүй, гаднах болон доторх план зургийг хавсаргаагүй. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Зуслангийн газар нь цахим бүртгэлд баталгаажаагүй, газрын кадастр давхардсан байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Автомашины хувийн хэргийг бүрэн хөтлөөгүй, дугуй шинээр олгохдоо заалтыг тэмдэглээгүй | 1 | 4,350.0 | | | | | 1 | 4,350.0 | | | | |
| Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сургалтад хоол хүргэлтийн үйлчилгээ авсан. | 1 | 7,500.0 | | | | | 1 | 7,500.0 | | | | |
| Шатахууны шаардах дээр талоны тоо ширхгийг бичээгүй, шатахууны бодит зарцуулалтаар нь зардалд бүртгээгүй. | 1 | 18,395.0 | | | | | 1 | 18,395.0 | | | | |
| **Дүн** | **6** | **31,679.3** | | | | | **6** | **31,679.3** | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудсанд 2025.9.01-ний өдрийн “Ажил гүйцэтгэх гэрээ”, 2025.10.20-ны өдрийн “Ур чадварын нэмэгдэл олгох тухай” мөн11,12 саруудын хавсралт файлуудыг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | - | | | | | 1 | - |